



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№235 /444/

2022.12.28

Цаг үе, үйл явдал

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД БАРИЛГАЧИН ДАЙЧДЫГ ДЭМЖИЖ АЖИЛЛАХААР БОЛЛОО



Монгол Улсын Засгийн газрын гишүүн Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга бригадын генерал С.Ганбямба, бригадын генерал Мөнхбаяр, БИЦУГ-ын дарга хурандаа Х.Батсайхан тэргүүтэй Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний удирдлагууд Зэвсэгт хүчний 017 дугаар ангид ажиллаа.

Эрхэм зочид төлөөлөгчдийг ангийн хүндэт харуул жагсан ҮЖҮНХ-ийн хамт олон Төрийн дуулал эгшиглүүлэн угтан авсны дараа ангийн захирагч хурандаа Б.Дорждэрэм Барилга угсралт, засварын ажил гүйцэтгэх боломж, тусгай зөвшөөрөл болон энэ онд хийж хэрэгжүүлсэн ажил, цэргийн сургалт

бэлтгэл, бүтээн байгуулалтын талаар танилцуулсан юм.

Батлан хамгаалах салбартаа бүтээн байгуулалтыг өрнүүлдэг Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонтой тус анги нь 2022 онд Барилгын мэргэжил олгох сургалтыг зохион байгуулж 108 цэргийн алба хаагчийг хамруулсан байна. Тэдгээрийн 10 хувь нь ахлагчийн бүрэлдэхүүн, 90 хувь нь хугацаат цэргийн алба хаагчид байсан төдийгүй Монгол Улсын ерөнхийлөгч "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд мод үржүүлгийн газар байгуулан таван төрлийн 172,600 ширхэг суулгац тарьж ургуулсан тухайгаа тайлагнасан юм.

Түүнчлэн хурандаа Б.Дорждэрэм тулгамдаж буй асуудлын талаар сайдад танилцуулж дэмжлэг туслалцаа авахаар боллоо. Тодруулбал ангийн байрлалд "Ахуйн үйлчилгээний төв" байгуулах, хугацаат цэргийн алба хаагчдад барилгын мэргэжил эзэмшүүлэх мэргэжлийн боловсрол олгох сургалтыг дахин зохион байгуулах дэмжлэгийг сайдад уламжилсан юм. Үүний дараа ажлын хэсгийн бүрэлдэхүүн хугацаат цэргийн албан хаагчдын шинэ байртай танилцаж, үлгэр жишээч тохилог байртай болсон талаар хэлэлцэн сайшааж байсан юм.

Х.УНДАРМАА



2022 ОНД АМЖИЛТ БҮТЭЭЛ ӨРНҮҮН БАЙЛАА

Зэвсэгт хүчний 017 дугаар ангийн захирагч хурандаа Б.ДОРЖДЭРЭМ:

-Энэ жил манай анги хамт олон бүтээн байгуулалт хийсэн амжилт арвинтай жил байлаа. Тухайлбал Зэвсэгт хүчний Барилга - Инженерийн цэргийн удирдах газрын штабын барилга, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн штабын барилга, Зэвсэгт хүчний 015 дугаар анги дээрх сумны үйлдвэр зэрэг барилга байгууламжийг бид ашиглалтад орууллаа.

Мөн Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн үйлдвэрийн 8641мкв дээврийг вимбрам материалаар хийж гүйцэтгэлээ. Энэ нь манай хамт олны хувьд шинэ технологи ашигласан онцлог үйл явдал байлаа. Өнөөдөр манай ангид Батлан хамгаалахын сайд ажиллаж хугацаат цэргийн албан хаагчдын амьдарч буй орчин, ангийн хийж гүйцэтгэж буй ажил, цаашдын зорилго зорилтуудын талаарх

танилцуулгыг сонслоо.

Манай анги 2020 оноос хойш гурав дахь удаагийн хугацаат цэргийн алба хаагчдаа хүлээж аваад байна. Тэдэнд зориулсан ахуйн үйлчилгээний байрыг барих асуудлыг шийдвэрлэж өглөө. Сэтгэгдэл маш өндөр байна. Тулгамдаад байсан асуудал болох хугацаат цэргийн алба хаагчдын хувцас, цагаан хэрэгсэл зэргийг угаахад хүндрэлтэй байсан бол одоо уг асуудал ингээд шийдэгдэхээр боллоо. Маш их талархаж байна.

Мөн манай хугацаат цэргийн алба хаагчид Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцан барилгын нарийн мэргэжил эзэмшин төгсөж байгаа. Эдгээр хугацаат цэргийн алба хаагчдаас ахлагчийн бүрэлдэхүүний нөхөн хангалтыг хийж байна. Жишээ нь 2021 онд хоёр хугацаат цэргийн алба хаагч ахлагчийн албанд элсэж байсан бол

энэ жил 28 хугацаат цэргийн алба хаагч ахлагчийн албанд элсэж байна. 2022 онд гол анхаарлаа чиглүүлэн ажилласан бүтээн байгуулалт бол БИЦУГ-ын штабын барилгын ажил байсан учир ангийн нийт бие бүрэлдэхүүний 80 гаруй хувь тус барилгын ажил дээр ажилласан.

Мөн бас нэгэн ололттой тал бол Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд Төв аймгийн Батсүмбэр суман дахь Гургалдайн гол орчим 5га газар Мод үржүүлгийн төвийг байгуулан ажиллаж 10 нэр төрлийн 180 гаруй мянган модыг үрсүүлж ургуулаад байна. Ирэх жил бид 2.5 газарт үргэлжлүүлэн мод тарихаар үрийг нь цаг хугацаанд нь түүж бэлтгэлээ. Одоогоор таван нэр төрлийн 200 кг үртэй. Цаашид хоёр сарыг дуустал үр, мөчир ургуулах, тариалалтын бэлтгэл зэргийг

хангана. Энэ ажлыг дэмжих үүднээс БИЦУГ-аас газар хагалах зориулалт бүхий "Кубота" трактор авсан, мөн анжис болон шаардлагатай материал хэрэгслийг авахаар төлөвлөж байна.

Ингэснээр газраа боловсруулах боломжтой болж байгаа тул мод үржүүлгийн ажил хэвийн явагдах юм. 2023 оны хувьд манай анги ЗХЖШ болон БИЦУГ-аас өгсөн үүргийн дагуу Богд уулын төмөр замын бүтээн байгуулалтад оролцож, үүрэг гүйцэтгэх төлөвлөгөөтэй байгаа. Мөн Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.

Эдгээр ажлын бэлтгэлийг хангаж байна. Мөн манай анги 2020 онд гүүрний барилгын ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд цаашид гүүр барих бүрэн бололцоотой.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

| ӨДӨР | ШӨНӨ |
|--------|--------|
| ☀️ -16 | 🌧️ -28 |


ӨМНӨД СУДАН

| ӨДӨР | ШӨНӨ |
|-------|-------|
| ☀️ 34 | 🌧️ 21 |

ВАЛҮТЫН ХАНШ

| ВАЛҮТ | АВАХ | ЗАРАХ |
|--------|-------|-------|
| USD 🇺🇸 | 3.459 | 3.464 |
| EUR 🇪🇺 | 3.688 | 3.698 |
| CNY 🇨🇳 | 493 | 496 |
| RUB 🇷🇺 | 48.60 | 49.60 |
| JPY 🇯🇵 | 25.85 | 26.20 |
| KRW 🇰🇷 | 2.67 | 2.70 |

ЗУРХАЙ



2022.12.28 / ЛХАГВА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 6

ӨВ ӨВЛИЙН ДУНД ХАР ХУЛГАНА САР НЭГ ЦАГААН МЭНГЭТЭЙ ХӨХӨГЧИН ТУУЛАЙ ӨДӨР

Үс засуулбал:

Өнгө зүс сайжирна
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
08.41-17.06

Барилдлага:

Идэр
Шүтэн барилдлага:
Нэр өнгө

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, үйл буруутгах, ламд золгох зэрэг цагаан зүгийн үйлэнд сайн. Баруун нүд татвал холын сураг сонсох, зүүн нь татвал эд олдох, баруун чих хангинавал ундаа олдох, зүүн чих хангинавал түлэгдэх, нохой уливал үхсэний сураг сонсох, хэрээ дуугарвал нөхөртэй учрах, тагнай загатнавал хувцас олдох, бие татвал хэцэг, эхэд муу. Хөл татвал хэрүүл, тэмцэл гарах муу ёр болой.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 662,753,388

Эдгэрсэн

Нийт: 635,362,430

Нас барсан

Нийт: 6,688,810

Цаг үе, үйл явдал

ОНЫ ОНЦЛОХ ХҮНЭЭР МОНГОЛЧУУДЫН АНХНЫ ЭМЭГТЭЙ ГЕНЕРАЛ ТОДРОВ



ойгоор зарлиг гаргаж, уламжлал ёсоор цэргийн цол гардуулав.

Тэдэн дунд онцгой нэгэн байсан нь ҮБХИС-ийн Сургалтын хэлтсийн дарга, хурандаа Ганболдын Болор Ерөнхийлөгчийн зарлигаар бригадын генерал цол хүртэж, Монгол Улсын зэвсэгт хүчний түүхэнд анхны эмэгтэй генерал төрлөө.

Тэр бол Цэргийн их сургуулийн анхны эмэгтэй сонсогчоос эхлээд НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд 2010 оноос эхлэн гурван удаа үүрэг гүйцэтгэж, АНУ-ын Агаарын цэргийн команд штабын коллеж, ХБНГУ-ын Олон улсын аюулгүй байдлын төв, Тайландын Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Дайны коллежид Олон улсын харилцаа, цэргийн стратеги судлалын магистрын зэрэг хамгаалсан цэргийн өндөр боловсролтой эмэгтэй.

НҮБ-аас зарласан нээлттэй ажлын байранд дэлхийн олон улсаас цэргийн 1000 гаруй алба хаагч өрсөлдөж, 10-13-хан офицерыг сонгож авахад хурандаа Г.Болор шалгарч, НҮБ-ын үндсэн ажилтнаар томилогдон ажиллаж байв. Монгол Улсын батлан хамгаалах салбарын үйл ажиллагаа дэлхийтэй мөр зэрэгцэн явааг баталж, мөрдэс нэгтнүүдээ олон улсын түвшинд үүрэг гүйцэтгэх үүд хаалгыг нээж өгсөн олон анхдагчийн эзэн Монгол Улсын анхны эмэгтэй генерал Г.Болорыг 2022 оны анхаарал татсан эрхмүүдийн нэг хэмээн нэрлэж байна гэжээ.

Хэвлэл мэдээллийн байгууллагууд 2022 онд нийгэмд хамгийн их дуулианыг тарьж, анхааралд орсон урлаг, спорт, нийгмийн онцлог хүмүүсийг зарласаар байна.

www.gogo.mn цахим сайтныхны онцлон зарласан 10 хүний нэгт ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын дарга, бригадын генерал Г.Болор багтжээ.

Түүний тухай өгүүлэхдээ "Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч У.Хүрэлсүх орчин цагийн Зэвсэгт хүчний 101 жилийн

МОНГОЛ ЦЭРГИЙН НЭГДСЭН ХОЛБООНООС АЛБА ХААГЧДЫН ХҮҮХДҮҮДЭД БЭЛЭГ ГАРДУУЛАВ



Шинэ жилийн баярыг тохиолдуулан Монгол цэргийн нэгдсэн холбооны "Эмэгтэйчүүдийн клуб"-ээс санаачлан төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын хүүхдүүдэд баярын бэлэг гардуулж өглөө.

Үйл ажиллагаанд хүндэт зочноор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Аюулгүй байдал, батлан хамгаалах бодлогын зөвлөх дэслэгч генерал Ц.Тогоо, Монгол цэргийн нэгдсэн холбооны ажлын албаны дарга Ж.Ванчинсүрэн нар оролцов.

Монгол цэргийн нэгдсэн холбооны ажлын албаны дарга Ж.Ванчинсүрэн "Манай холбооны Эмэгтэйчүүдийн клубээс жил бүр төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын хүүхдүүдийг баярлуулдаг. Энэ удаа бид БХЯ, ЗХЖШ, ХХЕГ, ЦЕГ, ОБЕГ, Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн зэрэг байгууллагуудын алба хаагчдын хүүхдүүдэд бэлэг гардуулж, мөн Монгол цэргийн нэгдсэн холбооны үйл ажиллагаатай танилцууллаа" гэв.

АГААРЫН ЦЭРГИЙН 2022 ОНЫ ШИЛДГҮҮД ТОДОРЛОО



Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлал 2022 онд хийж хэрэгжүүлсэн ажлаа тайлагнаж, цаашид хэрэгжүүлэх ажил, арга хэмжээ, бодлогоо тодотгохын зэрэгцээ энэ оны шилдгүүдээ тодрууллаа.

Тодруулбал, "Агаарын цэргийн Тэргүүний анги"-аар хурандаа Ш.Аюурзана захирагчтай Зэвсэгт хүчний 353 дугаар анги, "Агаарын цэргийн Тэргүүний салбар"-аар Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн хошууч Б.Мягмарсүрэн захирагчтай сөнөөгч онгоцны скадриль, "Агаарын цэргийн Тэргүүний офицер"-оор Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн Тоон систем автоматжуулалтын албаны дарга, электрон автоматжуулалтын инженер хошууч Г.Ганзориг, "Агаарын цэргийн Тэргүүний ахлагч"-аар

Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн ХРТХР-ийн радиомаркерын байрын гэрэлтүүлгийн тасгийн гэрэлтүүлгийн системийн техникч-жолооч ахлагч М.Хоролсүрэн, "Агаарын цэргийн Тэргүүний ажилчин албан хаагч"-аар Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн сантехникийн слесарь Г.Дашдэмбэрэл, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний бүтцийн нэгж"-ээр Хурандаа Г.Хашчулуун даргатай Материал техникийн хэлтэс, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний удирдах ажилтан"-аар Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Б.Мөнх-Ирээдүй, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний ахлах офицер"-оор Материал техникийн хэлтсийн техникийн хангалтын хангалтын ахлах

офицер хурандаа С.Дашдондог, "Агаарын цэргийн командлалын Тэргүүний офицер"-оор Хүний нөөцийн хэлтсийн нөхөн хангалтын офицер ахмад Н.Баттөр нар тус тус тодорлоо.

Шагналыг Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагч хурандаа Т.Ганбат болон Агаарын цэргийн штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат нар гардуулан өглөө.

Үйл ажиллагааны төгсгөлд нь хурандаа Т.Ганбат улиран одож буй 2022 онд бид амжилт бүтээлээ бататгасан, зорилго, зорилтоо хэрэгжүүлж, амжилт, бүтээлээр дүүрэн жил байсныг онцлоод бие бүрэлдэхүүнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсэн ерөөлөө.

"ҮЛГЭР ЖИШЭЭ"-ГИЙН СПОРТЫН АВАРГУУД ТОДОРЛОО



ЗХЖШ-ын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн нийт бие бүрэлдэхүүний дунд спортын цогцолбор тэмцээнийг сагсан бөмбөг, гар бөмбөг, ширээний теннис, дартсын төрлөөр энэ сарын 23-ны өдөр зохион байгуулж, дүнгээ гаргалаа.

Үүнээс дартсын тэмцээнд тэргүүн байрт хөгжимчин дэд ахлагч Э.Мөнхдэлгэр, дэд байрт хөгжимчин дэд ахлагч Б.Бямбатулга, ширээний теннисний төрөлд тэргүүн байрт хөгжимчин дэд ахлагч Б.Бямбатулга, дэд байрт хөгжимчин ахлах ахлагч Ч.Төгсбаяр нар шалгарсан юм.

Цогцолбор тэмцээний гар бөмбөгийн төрлөөр ахлах ахлагч Р.Отгонбаяр ахлагчтай нэгдүгээр группийн

баг тэргүүлсэн бол удаах байрт сургагч ахлагч Г.Гансэлэм ахлагчтай гуравдугаар группийн баг тамирчид шалгарав.

Мөн сагсан бөмбөгийн төрөлд сургагч ахлагч Г.Гансэлэм ахлагчтай гуравдугаар групп, ахлах ахлагч Н.Мөнхтулга ахлагчтай хоёрдугаар группийн баг тамирчид эхний байрыг эзэлж, хамт олноо манлайлав.

Энэхүү спортын цогцолбор тэмцээний нийлбэр дүнгээр сургагч ахлагч Г.Гансэлэм ахлагчтай гуравдугаар группийн хамт олон тэргүүлж, Өргөмжлөл, шилжин явах цомын эзэд боллоо.

Дэслэгч Б.АМГАЛАНБАЯР

Сургалт

МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №46

ТА ҮСЭГ БҮХИЙ УНШИХ, БИЧИХ ДАДЛАГА
Өмнөх хичээлээр үзсэн ТА гийгүүлэгч бүхий, уншихад хялбар, нэг юм уу хоёрхон үеэс бүтсэн, бичлэг дуудлага нь өнөөгийнхтэй бараг төлөв таардаг хялбар жишээ үгсийг унших, бичих дасгал дадлага хийцгээе. Зөв уншаад, хичээнгүй сайхан бичээрэй.
Дармал, бичмэл тигээр:

